

Академич, профессор Д.Батсуурь-Хэрлэнгийн геологийн экспедиц

С.Дашдаваа, Д.Чулуун, П.Дугараа

ШУТІС

Төр засгаас Их дээд сургуулиар мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох тухай 1972 оны 28-р тогтоол гарч <<Албан үйлдвэрийн газартай аж ахуйн гэрээ байгуулж эрдэм шинжилгээний ажлын хэмжээг нэмэгдүүлэх үндсэн дээр сургуулийг үйлдвэртэй холбох аж ахуйн гэрээгээр олсон орлогыг сургалт эрдэм шинжилгээний материаллаг баазыг бэхжүүлэх эрхийг их дээд сургуулийн ректоруудад зөвшөөрсөн>> заалтыг МУИС хамгийн түрүүнд хошуучлан хэрэгжүүлж эхэлсэн юм. Энэ заалтыг хэрэгжүүлэх явцад МУИС-д "Хөвсгелийн экспедици" байгуулагдаж Хөвсгөл далайг судлах иж бүрэн ажилд тус сургуулийн эрдэмтэн, багш оюутнууд Эрхүү хотын их дээд сургуультай хамтран ажиллаж эхэлсэн. Энэ үес тус сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор Д.Батсуурь Монгол орны ашигт малтмал, геологийн судалгаанд өөрийн сургуулийн залуу багш нарыг татан оролцуулах, хөрш зэргэлдээх орны их дээд сургуулиудын өндөр дадлага туршлагатай багш нараас сургах, хамтран ажиллах хэтийн их төлөвийг урьдчилан харж "Хэрлэнгийн геологийн экспедици"- ийг зохион байгуулах санаачлагыг гартаа авч хэрэгжүүлсэн хүний нэг юм. Бүр 1973 оноос МУИС-т геологийн салбарын залуу багш нар аж ахуйн гэрээгээр Хэрлэнгийн дунд ургалын (Дашбалбар) дүүрэгт 1:200000 масштабтай зураглалын ажлыг хийж эхэлсэн юм. МУИС ийн Ректор Ж.Батменх, Геологийн яамны сайд Ч.Хурц нарын гарын үсэг зурж баталсан гэрээт ажлыг хэрэгжүүлэх эрдэм судлалын чиглэлтэй болгох, ЗХУ-ын (Хуучин нэрээр) их дээд сургуулиудтай хамтран ажиллах, эрдэм шинжилгээний хурал хийх, бүтээл цуврал гаргах бүхий л ажлыг профессор Д.Батсуурьин ажлын баялаг туршлага, асар их нэр хүнд, хүнлэг сайхан сэтгэл, уул шиг их нөмөр нөөлгөөр амжилттай эхэлж улмаар хамтарсан экспедици байгуулах үндэс болсон юм. Хаяа зэргэлдээ нутаг, хүн зоны ойрын холбоонд үндэслэж Эрхүүгийн Политехникийн дээд сургууль, Эрхүүгийн УИС-н Геологийн факультет мен хотын Дэлхийн Царцасын хүрээлэнгийн өндөр мэргэжил дадлага туршлагатай эрдэмтэн багш наортай хамтарсан Хэрлэнгийн

геологийн экспедицийг академич Д.Батсуурь профессор С.Дашдаваа нарын уйтгагүй хөдөлмөрийн үр дүнд 1974 онд биселэлээ олж дээрх сургуулиудын Ректор академич Н.Содном, А.А.Игошин, Н.Ф.Лосев нар гарын үсэг зурж албан ёсоор үйл ажиллагаа эхлээд 30 гаруй жил боллоо. Экспедиц, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, сургалт гэсэн гурвалсан чиглэлтэй ажиллаж амжилтанд хүрсэний гарсаа зөв зам чиглэл байсныг академич Д.Батсуурьийн үйл ажиллагаанаас салгах аргагүй юм. Академич Д.Батсуурьийн шууд удирдлагын доор Хэрлэнгийн геологийн экспедицийн анхдугаар хурлыг 1977 онд Улаанбаатар хотод зохион байгуулж хурлын бэлтгэлийг сайн хангаж хурлын дараагийн экскурсыг Жанчивлан-Горхийн районд хийгээсн нь Зөвлөлтийн хуралд оролцсон төлөөлөгч нар өндөрөөр үнэлж байсныг дурьдахад таатай байна. Өнгөрсөн хугацаанд:

-Үйлдвэрлэлийн чиглэлээр 20 шахам мянган ам км талбайд геологийн зураглалын ажил хийж өнөөгийн ханшаар тэрбум гаруй төгрөгийн геологи хайгуулын ажил хийж нүүрсний 5, хайлуур жоншны 3, алтны 6, ховор холимог металлын 10 гаруй орд, илрэл олж улсын геологийн фонд, эрдсийн санд оруулжээ.

-Эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээр 7 хүн шинжлэх ухааны доктор, 16 хүн дэд докторын зэрэг хамгаалж эрдэм шинжилгээний 350 гаруй бүтээл, 7 монографи, экспедицийн бүтээлийн 20 цуврал, үйлдвэрлэлийн тайлан төсөл 20, сурхад бичиг 4, гарын авлага 17 бичиж 14 удаа олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулсан тоо гарч байна. Анхны төслийн үед эхэлж Цэнхэрийн голд геологийн зураглалын сургалтын хэсэрийн дадлага хийх газрыг сонгож 14 жил давхардсан тоогоор 1000 гаруй оюутан геологийн зураглалын ажлын анхны мэдэгдхүүн зээмшсэнээс гадна үйлдвэрлэлийн, дипломын өмнөх магистрын докторын дадлага судалгааны ажилд 200 гаруй оюутан оролцож дадлага туршлагатай сайн геологич эрдэмтэн болгоожээ. Манай олон залуу багш нарын сургалт судалгааны ажилд зөвлөлтийн эрдэмтэн Ю.А.Чернов, В.А.Наумов, В.В.Деми

дов, Г.С. Вахромеев, В.И. Сизых, Ю.В. Комаров
С.В. Новоселов, академич Ф.А. Летников, Л.В.
Таусон, Монголын академич
Б.Лувсандаанзан, О. Төмөртогоо нарын олон
багш эрдэмтдийн туршлага, зөвлөгөө
дэмжилгээр өсч бойжин өнөөгийн нэргтэй
эрлэмтэд, профессоруул болшигожээ.

-Хэрлэнгийн экспедици зөвхөн
Эрхүү, МУИС, ТИС ийн хүрээнээс хальж
ХБНГУ-ын Фрайбергийн уулын академи,
Чехийн Прагийн их сургууль БНХАУ-ын
Хэбэй мужийн Шижижуаны геологийн
институт зэрэг олон их дээд сургууль эрдэм
шинжилгээний байгууллага оролцсон олон
улсын хэмжээний экспедици болж судалгааг
Ази, Европын хэмжээнд хийж байна. Энэ
бүхний эх суурийг зөв завьж чиглүүлж өгсөнд
академич Д.Батсуурийн том гавьяа, зүтгэл
оршиж байгаа юм.

.Эндээс дүгнэлт хийж эргэн эргэн
дурсан санаад академич Д.Батсуурийн холч
мэргэн ухаан, хичнээн авьаслаг зохион
байгуулагч, түүний судалгаа шинжилгээний
ажлын арвин туршлага ирээдүйн их
хөгжлийн хэтийн төлөвийг, ялангуяа эх
орныхоо эрдэс баялгийг судлахад өөрийн
орны олон зуун геологчдыг бэлтгэхэд түүний
оруулсан хувь нэмэр үеийн үед дурсагдан
мөнхжүүлэх үйлс гавьяатай болохыг
Хэрлэнгийн геологийн экспедицийн үйл
ажиллагаатай салшгүй холбоотойг харуулж
байна.

Сайн үйлс дэлгэрэн мөнхжиж санасан бүхэн
нь хэрэгжин алдарших болтугай.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- [1] 1.Д.Батсуурь, В.А.Наумов, С.Дашдаваа
бусад
Деятельность Керуленской межвузовской
геологической экспедиции – яркий
пример тесного сотрудничество
монгольских советских геологов. В
кн: Вопросы геологии и металлогении
Восточной Монголии Улаанбаатар
.1979. стр 7-16
- [2] 2.О.Гэрэл, А.Н.Иванов
-Керуленская межвузовская
геологическая экспедиция :
30 лет плодотворного сотрудничества .
сэтгүүл Геологи.- 10. 2004.х.1-4